



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар А/142

Булган сум

“Бид Булганчууд” сар шинийн их золголтын  
зохион байгуулалтын зардалд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.10 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2026 оны А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арван долдугаар жарны Сүрээр дарагч “Гал морь жил”-ийн сар шинийн баярыг тохиолдуулан “Бид Булганчууд” нэгдсэн их золголтыг Улаанбаатар хотод 2026 оны 02 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 38,000,000 (гучин найман сая) төгрөгийг хавсралтаар баталж, аймгийн Засаг даргын “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх” хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д. ПҮРЭВ-ОЧИР



6326010187

Аймгийн Засаг даргын 2026 оны  
02 дугаар сарын 24 ны/ний өдрийн  
А/ИД дугаар захирамжийн хавсралт



**“БИД БУЛГАНЧУУД” САР ШИНИЙН ИХ ЗОЛГОЛТЫН  
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРДАЛ**

Д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	2	3	4	5
1	Ууц	3	500,000	1,500,000
2	Өвчүү	4	400,000	1,600,000
3.	Хиам, огурци	1	500,000	500,000
4	Жимс багц	5	220,000	1,100,000
5	Айраг	700	10,000	7,000,000
6	Цагаан идээний багц	130	63,000	8,190,000
7	Арын өрөөний хоол	100	60,000	6,000,000
8	Ус шилтэй /Millina/	1000	3200	3,200,000
9	Ундаа лаазтай	1000	3500	3,500,000
10	Нэг удаагийн аяга таваг	1	600,000	600,000
11	Бэлгийн хайрцаг	130	37,000	4,810,000
	<b>Нийт дүн</b>			<b>38,000,000</b>

--o00o--